

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсангийн Чимэдрэвдан	Дугаар	L005
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг
Төрсөн газар	Хөвсгөл аймгийн Бүрэгхаан сум	Төрсөн он	1913
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тэсийн хүрээ буюу Дүүрэгчийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЦЦ 027
Одоогийн сүм хийд	Дашчойлин хийд	Сүм хийдийн дугаар	УВ 02
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 12-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Хөвсгөл аймгийн Рашаант сумын Эрдэнэ Дүүрэгч вангийн хошуу хийд

Манай хүрээ Хөвсгөл аймгийн Рашаант сумын Сангийн далайд байсан. Эрдэнэ Дүүрэгч вангийн хошууны хийд. Хүрээний ойр орчимд Дэлгэрхаан, Хул азарга, Дэдэнлхүмбэ гэсэн тахилгатай уул байсан. 1000 гаран 2000 хүрэхтэй үгүйтэй ламтай байсан. Хүрээ дэгтэй хийд байсан. Уншлага хурал ном нь Хүрээтэй адил байсан.

Дүүрэгчийн хүрээ 30 гаруй дугантай байсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 1

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

- 1.Цогчэн
  - 2.Чойр
  - 3.Манба
  - 4.Дүйнхор
  - 5.Жүд
  - 6.Зурхай
  - 7.Чого
  - 8.Жанчивлан
  - 9.Дарь эх
  - 10.Шүтээний их
  - 11.Шүтээний бага
  - 12.Нүгнээний
  - 13.Гүнрэгийн
  - 14.Эрдэнийн Ганжуурын
  - 15.Алтан Ганжуурын
  - 16.Жасын
  - 17.Голын ордны (ноёдын дуган)
- 6 аймгийн дуган байна.

- 1.Сангай
- 2.Хотгойд
- 3.Тоос
- 4.Жүнгээ
- 5.Гол
- 6.Цээж гэсэн дугануудтай байсан.

Өдөрт Цогчэн хурна. Чойрт өдрийн шаржин хурна. Чойрт хаврын сарын хурал гэж бий. Зуны сарын хурал гэж бас бий. Намрын сарын, өвлийн сарын хурал гэж бас бий. Чойр, Манбад хурлуудаас гадна Чойрт гавж, Манбад маарамба болно. Хүрээ хэдэн онд байгуулагдсаныг мэдэхгүй. Нэлээн эртнийх л байх.

Дүүрэгчийн хүрээ гэж нэрлэдэг байсан. Дүүрэгч вангийн хошууныхан шавилан суудаг байсан.

Хийдийн гол сахиус Сэндом байсан.

Хийдийн хамба лам нь хамгийн сүүлд хоёр Сэнгэ байсан. Жанчив Сэнгэ, Умын Сэнгэ гэж байсан. Цогчэн таван унзад байдаг байсан. Чойрын, жүдийн, зурхайн шунлайв гэж байсан. Би нэрийг нь мартчихаад байна аа.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 2

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хийдэд хутагт хувилгаад, эрдэмтэй лам нар байсан. Хувилгаан байгаагүй.

Цагаан сараар газар болгон шахуу Цэдор хурна. Дараа нь Эхийнд, Манбынд ерөөл хурна. Цам зуны адаг сарын шинийн нэгэнд гарна. 100 гаруй дүр гардаг байсан байх. Хангалууд, Хашин хаан гээд бүгдээрээ байсан. Цам 1930-аад он хүртэл л байсан байлгүй дээ. Майдар зуны адаг сарын 15-нд эргэнэ. Майдарын цам гарна. Майдар эргэхэд сүсэгтнүүд хүрээнд их ирнэ. Ганжуур эргэнэ. Хүрээгээ эргэнэ. Хошуугаа тойроод бас эргэнэ. Хүрээгээ тойрч эргэхэд Ганжуураа тэврэнэ, үүрнэ, мөн тэргэн дээр ч ачаад явдаг байсан. Хайлантай байсан. Хайланд гэлэн, гэцэл нийлсэн 40, 50 хүн хурдаг байсан. Нүгнээ сахина. Үүрдийн нүгнээ нэг бий. Үргэлж сахиж байдаг. Саналаараа сахина. Нэг лам 15 хоног сууна.

Би Чойр, Манба дацанд хурж байсан. Би Чойрт 20-иод жил хурсан. Би гаарамба нийлсэн. Манай зиндаа 70-аад хүнтэй байсан байх. Одоо үлдсэн хүн алга. Чойрын сургалтын игчаа нь Гүнчэн лам. Гаарамбад нийлтэл 10 хэдэн жил болсон байна. Зиндаа нь хадаг, (шидүв гэж байгаагүй) жумбарай, юлжин, дондонжу, ог, гом, гадамба, дом, умсарва, умнянба, зод, гаарамба ог, гаарамба гэж байсан юм. Хүрээн дээрээ гавжийн дамжаа барина. Жилд хоёр удаа барина. Хавар, намар хоёр барина. Нэг удаа 3 хүн, жилдээ доод тал нь 6 хүн гавжийн дамжаа барина. Нэг хүн хоёр хоног барина.

Хийдэд бархан байгаагүй. Лам нарт бар байдаг байсан.

Хүрээний ойролцоо Гандан хүрээ гэж байсан. Одоогийн Түнхээл тал руу байсан. Далайн хүрээ гэж байсан. Энэ хоёр хүрээтэйгээ ирж очилцдог байсан.

Суварга байсан. Хэд байсныг нь санахгүй байсан. Чойрын дуганыг тойроод хүрд байдаг байсан.

Олон жастай байсан. Хамгийн баян жас нь Эрдэнийн Ганжуур, Алтан Ганжуурын жас байсан. Цогчэн жас том байхаас баян байгаагүй.

Лам нар нь хүрээн дотроо сууна. 6 аймгаар аймаглаж сууна. Хийдэд тусгай лүйжингийн дуган гэж байгаагүй.

1929 (1939) онд хаагдсан. Эвдэхийг нь эвдээд, сүйдлэхийг нь сүйдлээ биз дээ. Би хар болсноос хойш хоршоонд, улсын худалдаанд их байлаа. Хөвсөл аймгийн Цэцэрлэг, Бүрэнхаан сумдуудад амьдарч байсан. Улаанбаатарт ирээд Хэвлэлийн комбинатад ажиллаж байсан.

Манай хийд сэргээгдсэн. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд байгаа. Одоо нэг хэдэн цөөхөн лам байна уу үгүй юу мэдэхгүй байна. 1990 онд Дашчойлин хийдийг байгуулагдахад орж хурсан.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн 3 хувийн мэдээллээс бүрдсэн болно.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 4